

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЦЭВЭР ТЕХНОЛОГИ

“Сэргээгдэх эрчим хүч, цэвэр бохир усны технологи, эрчим хүч, байгаль орчин, хог хаягдал, дахин боловсруулалт, дэд бүтэц”

Израиль улсад болох мэргэжлийн сургалт-аяллын танилцуулга

Израиль орны туршлага



Израиль улс нь технологийн дэвшлийг хөшүүрэг болгосон байгальд ээлтэй цэвэр технологиор дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг юм. Технологийн энэхүү дэвшил нь хомсдож байгаа нөөц баялагийг зохистой ашиглахад бүрэн чиглэгдэж байна. Тус улс нь байгальд ээлтэй цэвэр технологийн чиглэлд нэгэнт бий болсон амжилтыг даруй хоёр дахин нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Тухайлбал, усны нөөц хомсодсонтой холбоотойгоор хаягдал усыг дахин боловсруулах технологи, дуслын усалгааны систем, далайн усны давсыг шүүж цэвэрлэх технологийг өндөр түвшинд хөгжүүлсэн байна. Эдгээр шилдэг техник технологи нь анх засгийн газрын хөтөлбөрүүд, судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, технологи бойжуулах төслүүд, үйлдвэрийн удирдлагуудын санхүүжилтээр эхэлжээ. Жилийн нартай өдрийн тоогоор давуутай байдлаа ашиглан гарааны бизнес эрхлэгчдээс эхлээд том компаниуд, айл өрх, үйлдвэрлэл, газар тариаланд нарны дулаан болон эрчим хүч ашиглах технологийг эрчимтэй хөгжүүлж байна.

Израиль улс цэвэр технологийг бойжуулагч орон болж, энэ чиглэлийг урамшуулан дэмжсэнээр шинэ техник технологийн нээлт хийхийг эрмэлзсэн гарааны бизнес эрхлэгчид олноор төрж байгаа бөгөөд тэд ялангуяа байгалийн нөөц баялагийн хомсдолтой орнуудтай туршлагаа хуваалцаж, зах зээлээ өргөжүүлэхэд бэлэн байна.

Сургалтын агvvлга

Долоо хоногийн энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь Израйлийн байгальд ээлтэй цэвэр технологийн салбарт гарсан ололт амжилт, туршлагад тулгуурлан явагдах ба дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ.

- Эдийн засгийн хөгжилд сэргээгдэх эрчим хүчний ач тус
- Цэвэр болон хаягдал усны менежментийн шийдэлд ядуурал-хүрээлэн буй орчны харилцан хамаарал
- Хог хаягдал, дахин боловсруулалтын оновчтой шийдлүүд

Хөтөлбөр



Танхимын хичээлүүд, холбогдох мэргэжлийн хүмүүстэй хийх уулзалт, цэвэр технологитой газар дээр нь танилцах сургалт-аялалууд нь оролцогчдод нийгмийн хөгжилд цэвэр технологийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг бодитой таниулж, мэргэжлийн хэлхээ холбоо, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж бүрдүүлэх юм.

Дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн болон хувийн хэвшлийн үйлдвэрүүдтэй танилцана.

- Сэргээгдэх эрчим хүч (нарны, салхины, био)-ний технологи
 - Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжилд сэргээгдэх эрчим хүчний ач тус
 - Хотын, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн хаягдал ус боловсруулах технологи
 - Усны менежментийн салбарын өндөр технологийн шийдлүүд
 - Хог хаягдлаас эрчим хүч гарган авах төслүүд
 - Хог хаягдал болон дахин боловсруулалтын оновчтой шийдлүүд
- Хэрэгжиж буй төслүүдтэй газар дээр нь танилцаж, нэвтрүүлэх боломжтой туршлагыг эх үүсвэрээс нь шууд суралцах болно.

Хэн оролцох вэ?

Энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь хөдөөгийн хөгжил, байгаль орчин, хөдөө аж ахуй, газар тариалан, нөөцийн менежмент, төлөвлөлт, эдийн засгийн чиглэлийн төр засгийн байгууллага, яамдын бодлого боловсруулж, шийдвэр гаргах түвшний албан тушаалтан болон дээрх чиглэлийн орон нутгийн төр захиргааны байгууллагын ажиллагсад, олон нийтийн байгууллага болон хувийн хэвшлийн төлөөлөл, сонирхогчдод зориулагдсан болно.

Түүх, дурсгалын аялал

Израиль нь жүүд, христос, лалын шашны сүм хийд, дурсгалт газрууд ихтэй. Мэргэжлийн сургалт-аялалын үер Ирусалем хотын эртний дурсгалт газрууд болон Галилей нуурын эргэн тойрны үзэсгэлэнт байгаль, Сөнөсөн тэнгисээр аялна.

Мэргэжлийн сургалт-аялалын хөтөлбөр

- Туршлага судлах мэргэжлийн сургалт-аялалууд, мэргэжлийн уулзалтууд
- Нисэх онгоцны буудлаас угтах, үдэх унааны үйлчилгээ
- Орон нутагт зорчих болон дурсгалт газруудад нэвтрэх эрх
- Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн үйлчилгээ
- Израйлд байх хугацааны эрүүл мэндийн даатгал
- Өглөө, үдийн хоол
- Зочид буудлын зардал
- Ирусалем болон Назарет хоттой танилцах аялал

Сургалт-аяллыг зохион байгуулагч:

Weitz Center for Sustainable Development, Israel

Ногоон гариг-Ногоон ирээдүй ТББ, Улаанбаатар

Холбоо барих:

Монголд: Н.Оюундарь: earthgreen.ngo@gmail.com Утас: 95052526

Израильд: Ms. Adi Dishon: adi@weitz-center.org; Telephone: 972-8-9474111; Cellular: 972-50-4217616